# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 25 өдөр Дугаар 2/06 Баянбулаг

Сумын 2025 оны нийгэм, эдийн засгийг
хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.8, 35.1.18 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын 2025 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Сумын 2025 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг жил бүрийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, хэрэгжилтийг хангуулан, биелэлтийн явцыг танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Гансүх)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Болормаа)-д даалгасугай.

ДАРГА Т.ГАНБАТ

648803177

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024
оны 12 сарын 25 -ны өдрийн II
хуралдааны 3/06 дугаар тогтоолын хавсралт

БАЯНЦАГААН СУМЫН 2025 ОНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 11

Баянбулаг

| № | Бодлогын үндэслэл | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | | Хөрөнгө | Үндсэн хариуцагч, хамтрагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин | Зорилтот түвшин | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **1.1 Хөгжсөн иргэн -Хөгжлийг бүтээнэ.** | | | | | | | |
| 1 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.1.7 дэх заалт | Сумын хүний нөөц, боловсон хүчний нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийг сум байгууллагын хүрээнд хэрэгжүүлж ажилласан байна. | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар тогтоолоор “Баянцагаан сумын 2024-2028 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөтөлбөр”-г батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. | Сумын хүний нөөцийн нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд байгууллагуудын сул орон тоо нөхөгдөнө, шаардлагтай, ховор мэргэжлийн суралцагчидтай гэрээ байгуулах, дэмжих, урамшуулал олгосон байна. | ЗДНөөц 6,0 сая | Албан байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нар |
| 2 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1 дэхь заалт | Чуулга уулзалтуудын арга хэмжээг , зохион байгуулах | Чуулганд оролцсон идэрчүүд, залуучуудын тоо | Сум, бүсийн хэмжээний чуулга уулзалт зохион байгуулах хэрэгцээ шаардлага байгаа | Чуулга уулзалтууд зохион байгуулагдсан байна. | ОНХС 20,0 сая | ЗДТГазар, Төсөвт албан байгууллагууд, БЗД нар |
| **1.2 Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл** | | | | | | | |
| 3 | | Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулан, иргэдийн эрүүл мэндийг дэмжиж, “Эрүүл иргэн – Хонгорын баялаг” арга хэмжээг сумын төвшинд хэрэгжүүлэх | 2025-2028 | ОНТ | Тухай бүр | Байгууллагын төсөв | Эрүүл мэндийн төв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.4 дэх заалт | Монгол орон даяар хэрэгжиж буй Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах | Хамрагдалтыг 70-дээш хувь хүргэх | 30% | 70% | Байгууллагын төсөв 3 сая | Эрүүл мэндийн төв |
| 5 | | Сумын нийт хүн амыг 2 жил тутамд хавдар, халдварт бус өвчний эрт илрүүлэгт хамруулах ажлыг аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулах | Эрт илрүүлэгт иргэдийг хамруулах | 80 хувь | 71 хувь | ОНТ, Байгууллагын төсөв | ЭМТ, Байгууллагуудын дарга, захирал эрхлэгч нар |
| 6 | | Хүүхдийн амны хөндийн өвчлөлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулах, эмч урьж ажиллуулах, СӨБ, ЕБСургуулийн хүүхдүүдэд шүд угаах арга техникт суралцуулах, уралдаан зарлах | Амны хөндийн өвчлөлтэй 307 хүүхэд байгааг 80-аас дээш хувь эмчлэн эрүүлжүүлэх | 10% | 80% | Байгууллагын төсөв, ЗДНөөц 2,0 сая | ЗДТГ, ЭМТөв |
| 7 | | Шүдний эмчийг тогтмол ажиллуулах, тоног төхөөрөмжөөр хангах, кабинет тохижуулах | Дутагдалтай байгаа боловсон хүчний нөөц бүрдүүлснээр | Шүдний эмч, тоног төхөөрөмжгүй байгаа. | Тоног төхөөрөмжтэй болж эмч ажиллаж эхэлсэн байна. | Улсын төсөв, Байгууллагын төсөв-78,0 | ЭМТөв |
| 8 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.5 дэх заалт | Иргэдийн эмийн гаж нөлөө, зөв зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоог хангах ажлыг үе шаттай зохион байгуулах | Төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаснаар | Эмийг зөв зохистой хэрглэх мэдлэг дутмаг | Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангана. | Байгууллагын төсөв | ЭМТөв,Эмийн эргэлтийн сан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | | Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах сургалтыг зохион байгуулах | Сургалт зохион байгуулагдснаар | Өрхийн эрүүл ахуйн стандартын савны хэрэглээний түвшин бага байгаа | Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг нийт өрхийн 70 хувьд хүргэж бууруулсан байна. | ОНТ, байгуулл агын төсөв | ЭМТөв, НЭМА, Хяналтын зөвлөл |
| 10 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2 дэхь заалт | Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | Хөтөлбөр хэрэгжсэнээр | ЭМЯ сайдын тушаалтай | Хөтөлбөр батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна. | Байгуулл агын төсөв-5 сая төгрөг | ЭМТ |
| 11 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1 дэхь заалт | Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг акталж буулгах | Талбай цэвэрлэж дахин төлөвлөлт хийнэ | Хуучин барилга ашиглалтын хугацаа дууссан | Газар бүрэн чөлөөлөгдсөн байна. | Байгуулл агын төсөв 10.0 сая | СЗД,ИТХ, ЭМТ |
| 12 | | Эмчийн байр, өргөтгөлийн барилгад засвар хийх | Засвар хийснээр | Засвар хийх шаардлагатай байгаа | Засвар хийгдэж ажлын байрны нөхцөл сайжирсан байна. | Байгуулл агын төсөв 20 сая | ЭМТөв |
| 13 | | Эрүүл мэндийн төвийн хог шатаах зуухыг барих | Зуухтай болсноор | Хог шатаах зориулалтын зуухгүй | Эмнэлэгийн хог шатаах зориулалтын зуух баригдсан байна. | Байгуулл агын төсөв | ЭМТөв |
| 14 | | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах | Эмнэлгийн тоног төхөөрөмж бүрэн хангагдсанаар | 90% | 95% | Байгуулл агын төсөв 20 сая | ЭМТөв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | Байгууллагын албан хаагчид, хэвтэн эмчлүүлэгчдийн чийрэгжүүлэлтийн гадна талбайг байгуулах | Хуучин эмнэлгийн суурин дээр байгуулна | Чийрэгжүүлэлтийн зориулалтын талбай байхгүй | Тохижолт бүрэн хийгдэнэ. | Байгууллагын төсөв 20 сая | ЭМТөв |
| **1.3 Боловсролын чанар хөгжлийн тулгуур** | | | | | | | |
| 16 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалт | Сургууль, Цэцэрлэгийн Ариун цэврийн байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх | Ариун цэврийн байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх | 8 суултуур | Сургууль-16 суултуур Цэцэрлэг-17 суултуур | Улсын төсөв | СӨБ, ЕБС-ийн захиргаа |
| 17 | | ЕБС-ийн хичээлийн 2 байрыг ашиглалтад оруулах (320 хүүхэд) | Хичээлийн байрыг барих шаардлагатай | 100% гүйцэтгэлтэй болох | Барилга 75% гүйцэтгэлтэй байгаа | 5,200,0 | ИТХ, ЗД, ЕБС |
| 18 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2 дэх заалт | Бага, суурь боловсролын математик , англи хэлний сургалтыг дэмжих Eduten , Pearson хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн үр дүнгээр | 2023-2024 оны хичээлийн жилд тодорхой ажлууд зохион байгуулсан. | 3,4 ангийн сурагчдын математик, 5,6 ангийн сурагчдын англи хэлний чадварууд нэмэгдэж ,сурлагын чанарт ахиц гарч сургалтын орчин бүрдсэн байна. | Байгууллагын төсөв-1 сая | ИТХ, ЕБС |
| 19 | Боловсрол шинжлэх ухааны яамны зорилго, зорилт, алсын хараа-2050 | Сургууль, Цэцэрлэгийн багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг дэмжих, арга зүйг хөгжүүлэх, тэргүүний сургуулиудын туршлага судлах, багш сурагч солилцоо хөтөлбөр хэрэгжүүлэх | Туршлага солилцох уулзалт, арга хэмжээнд оролцогсодын тоогоор | Туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах | Туршлага судлах ажлыг орон нутгийн дэмжлэг, оролцоотойгоор зохион байгуулсан байх | Байгууллагын төсөв | ИТХ, ЗД, ЕБС, СӨБ |
| 20 | | Засаг даргын нэрэмжит стандарт хангалтын шалгалтыг зохион байгуулж үр дүнг тооцон, амжилт гаргасан багш, анги бүлгийг дэмжих, тайлант хурал зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр сурлагын ахиц амжилтыг нэмэгдүүлнэ | Яамнаас тогтоосон стандарт хангалтын нормативыг мөрдөж байна. | ЕБС-62.2 СӨБ-90,1 | Засаг даргын нөөц хөрөнгө | ЗДТГ, ЕБС, СӨБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Боловсрол шинжлэх ухааны яамны зорилго, урт хугацааны болон дунд хугацааны төлөвлөлт | Хос бичигтэн сум" сумын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчид, иргэдийн үндэсний бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадваржуулах | Анхан шатны сургалуудтыг зохион байгуулсан, хэлний бодлогын зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон | Дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж үндэсний бичиг үсгийн боловсрол сайжирсан байна | ЗДНөөц хөрөнгө, орон нутгийн төсөв | Хэлний бодлогийн зөвлөл |
| 22 | | Гамшгийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж ажиллах | Зохион байгуулсан сургалт, дадлага, оролцогчдын тоогоор | Гамшгийн талаарх мэдлэг ойлголтыг сургуулийн насны суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан боловсруулсан байх | Сургуулийн хэмжээний нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэн ажилласан байна | Байгууллагын төсөв - 1 сая | Сумын Хамтрасан баг, Сургуулийн хүүхэд хамгааллын баг, ЭХАБүлэг |
| 23 | | Хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлж орчны MNS6782:2019, MNS6781:2019 стандартыг хангаж ажиллах, | Эрсдэлийн үнэлгээгээний нэгтгэлээр | Эрүүл ахуйн ариун цэврийн байгууламж, орчны тэмдэг тэмдэглэгээ, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын орчинг нэмэгдүүлэх, эрүүл хамгаалагдсан орчин бүрдүүлэх | Хүүхдийн орчны эрсдэлийг үнэлэх үнэлгээний маягтын дагуу үнэлж,стандартыг хангахад чиглэсэн ажлыг зохион байгуулсан байх | БШУЯам хөрөнгө оруулалтаар 3000000 төг | ИТХ, Сургуулийн захиргаа, СӨБ, Хамтарсан баг |
| 24 | | "Хүүхдээ сонсъё-Хүүхдэдээ тайлагная" уриан дор хүүхдийн чуулганыг зохион байгуулах | Чуулганд оролцсон хүүхдийн тоогоор | Намар, хавартаа хүүхдийн чуулганаа зохион байгуулж байна. | Хүүхдийн чуулган зохион байгуулж тэдний гаргаж ирсэн асуудлыг холбогдох хүмүүст хүргэн шийдвэрлүүлсэн байна. | ЗД нөөцөөс 500000 мян/төг | ИТХ, Сургуулийн захиргаа, Хамтарсан баг Хүүхдийн төлөө зөвлөл |
| 25 | Боловсрол шинжлэх ухааны яамны зорилго, зорилт | Цэцэрлэг сургуулийн сурагчдад "Сүү" хөтөлбөр арга хэмжээг нутгийн захиргааны байгууллага, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж хүүхдийн эрүүл мэнд, өсөлтийг дэмжин ажиллах | Хэрэгжүүлсэн байдлаар | Сүү арга хэмжээний талаар эцэг эх олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллах | Анги бүр сүү хөтөлбөрийг эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлсэн байна. | Орон нутгийн төсөв, байгууллагын төсөв | Хүүхдийн төлөө зөвлөл, сургуулийн захиргаа |
| 26 | 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн "журамд өөрчлөлт | Байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр аймаг, улсын | Аймаг, улсын дундаж түвшинд | Улсын дундаж – 90,22% | Байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн | Байгууллагын төсвөөс | ЗД, ЕБС,СӨБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулах тухай" 252 дугаар тогтоол, | дунджийг хангасан аймаг, улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн багш нарыг дэмжих, урамшуулах туршлагыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах | хүрсэн багш нарын тоогоор | Аймгийн дундаж – 90,25%<br>Сургуулийн дундаж – 92,63% | үнэлгээгээр индексийн 1, 2-р түвшинд үнэлэгдсэн байна. | | |
| 27 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.1.2 заалт | Цахим танхимын тоог нэмэгдүүлэх | Кабинетийг нэмж байгуулснаар | Цахим танхим байгуулсан боловч нэг хүүхдэд ногдох тоног төхөөрөмжийн хүрэлцээ дутмаг | Орчин үеийн сургалтын хэрэгцээ шаардлагад нийцсэн цахим танхимтай болсноор сургалтын таатай орчин бүрдэж сурлагын чанарт ахиц ,амжилт гарсан байна. | Аймгийн ОНХСан 20,0 сая | ИТХ, ЗДТГ, ЕБС |
| | **1.4 Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ** | | | | | | |
| 28 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.1 дэх заалт | Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлж, хөдөөд чиглүүлнэ. | Хөдөөгийн багийн иргэдэд хүрч ажилласнаар. | Бусийн Баян-Өндөр, Шинэжинст сумдад 4 удаагийн урлагийн тоглолт, өөрийн сумд 9 удаагийн урлагийн тоглолт, хөдөөгийн 3 багт 4 удаагийн урлагийн тоглолт, номын сангийн үйлчилгээ, хөтөлбөрт цэнгүүнийг тус тус бэлтгэн хүргэсэн | Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж соёлын үйлчилгээг 2-3 удаа хүргэх. | Байгууллагын төсөв 2.0 | ИТХ, ЗДТГ, Соёлын төв |
| 29 | | Номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, сан хөмрөгийг баяжуулан, иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлнэ | Номын сангийн үйлчилгээ өргөжсөн байна. Уншигчдын тоогоор | Өдөр тутамын ном уншлагын үйл ажиллагаа явагдаж байна. | Иргэн бүр ном унших дадал хэвшилтэй болсон байна. | Байгууллагын төсөв | Соёлын төв |
| 30 | | Мэргэжлийн багш нарын дугуйланг тогтмолжуулж үр дүнг тайлагнасан уран бүтээлийг нийтийн хүртээл болгоно. | Дугуйланг тогтмолжуулан хичээлүүлж тайлан тоглолтыг иргэдэд хүргэснээр. | Морин хуур, бүжгийн дугуйлангийн сурагчдын тайлан тоглолтууд 2022, 2023 онуудад зохион байгуулагдсан. Сонгон дугуйлангууд | дугуйлангийн сурагчдын нэгдсэн тайлан тоглолтыг өөрийн сум болон бусийн Баян-Өндөр, Шинэжинст сумдад хүргэн ажиллана. | Байгууллагын төсөв 3,0 | Соёлын төв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтмол хичээллэж байна. | | | |
| 31 | | Соёлын болон соён гэгээрүүлэх ажлыг бодлогоор хэрэгжүүлнэ. Сумын ард иргэдийг соён гэгээрүүлэх, иргэдийн харилцаа хандлагыг сайжруулах, амьдралын зөв дадал хэвшилд сургах сургалт, урлаг, спортын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна. | Сумын нийт иргэдийн дундах зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, мэдээлэл, спорт, биеийн тамир, урлагийн цогц арга хэмжээг зохион байгуулан ажилласнаар. | Нийгмийн анги бүлгүүдийн чуулга уулзалт, урлаг, спортын цогц арга хэмжээнүүд зохион байгуулагддаг. | Иргэдийн сурч боловсрох, хөгжих эрх хангагдсан байна | Байгууллагын төсөв 3,0 | ИТХ, ЗДТГ Соёлын төв |
| 32 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.1 заалт | Удмын санг хамгаалах, угийн бичиг хөтлөлтийн ач холбогдлыг залуучуудад сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. | Нийт өрхийн 20-оос дээш хувь нь угийн бичиг хөтөлж хэвшсэн байх. Хугацаа: Хагас бүтэн жилээр тайлагнах | Угийн бичиг хөтлөх анхан болон дунд шатны сургалт зохион байгуулагдсан. "Мөнх сум"- овгийн угийн бичгийг хэвлүүлж номын сангийн архивд хүлээлгэн өгсөн. | Нутгийн иргэдийн удмын санг хамгаална. Угийн бичиг хөтлөх сургалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлнэ. | Байгууллагын төсөв 1.5 | Соёлын төв, ИТХ, ЗДТГ |
| 33 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.4 заалт | ТСҮХДГ-ын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, малчидтай гэрээ хийж хариуцуулан, хамтран ажиллах, тэдгээрт түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлснээр. | Аймаг, сумын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг гэрээгээр хамгаалж, аялал жуулчлалыг хөгжүүлснээр. | Аймгийн хамгаалалтад байх 2, сумын хамгаалалтад байх 9-н түүх соёлын дурсгалт газруудад түшиглэсэн "Миний нутгийн бахархал" тойрон аяллыг зохион байгуулж 261 сурагч 9 багш хамрагдсан. | ТСҮХДГ-ыг хамгаалалтын гэрээг шинэчлэн байгуулж, тэдгээрт түшиглэсэн аялалыг эрчимжүүлж, хөгжүүлэн ажиллана. | Байгууллагын төсөв 1.5 | Соёлын төв, ЕБС |
| 34 | | Амарбуянт бусийн онцлоготой урлаг, соёлын биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, орон нутаг судлах танхимын бүтээгдэхүүн үзмэрийг баяжуулах, сурталчлан | Амарбуянт бусийн ардын урлагийн наадам зохион байгуулснаар. | 3 жил тутамд нэг удаа уламжлал болгон зохион байгуулдаг. | Амарбуянт бусийн ардын урлагийн наадмыг зохион байгуулна. | Байгууллагын төсөв 3.0 | Соёлын төв |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | таниулах ажлыг бодлогоор дэмжинэ. | | | | | |
| 35 | | Хүүхдийн хөгжлийн сургалтуудыг хичээлүүлэх. | Морин хуур, сурын харваа, шагайн харвааны дугуйланг хичээлүүлснээр | Үндэсний хөгжим, дуу, бүжгийн дугуйлан хичээллэж байна. | Морин хуур, Үндэсний сурын харваа, Шагайн харваан сургалтуудыг хичээллүүлэх. | Байгууллагын төсөв | Соёлын төв Сурын холбоо Шагайн холбоо |
| 36 | | Хүний хөгжлийн олон талт арга хэмжээг зохион байгуулан ажиллах. | Үйл ажиллагаа зохион байгуулснаар. | Эрүүл мэнд, Соёл, боловсролын чиглэлийн сургалт уулзалтууд зохион байгуулагддаг. | Хүний хөгжлийн олон талт цогц арга хэмжээг төлөвлөн ажиллаж хийт иргэдэд хүрч ажиллах_. | Байгууллагын төсөв | Соёлын төв |
| **1.5 Идэвхтэй амьдрал - Чийрэг иргэн** | | | | | | | |
| 37 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.2.1 дэх заалт | Үндэсний спортын бүсийн чанартай уралдаан тэмцээн зохион байгуулах | Зохион байгуулагдсан тэмцээн уралдаан, оролцогдын тоогоор | Байр залны хүрэлцээ муу байдаг | Тэмцээн уралдаан зохиогдсон байна. | ОНТөсөв | БТАрга зүйч Н.Ерөөлт-Очир |
| 38 | | СӨБ, ЕБС-ийн суралцагчдын дунд үндэсний спортын сонгон дугуйлан хичээлүүлэх | Сонгон дугуйланд оролцож буй хүүхдүүдийн тоогоор | Үндэсний спортын сонгон дугуйлан хичээллэх заал танхимын хүрэлцээ тутмаг байдаг | Хүүхдүүдийн авьяас чадварыг нээж хөгжүүлсэн байна. | ОНТөсөв, Байгууллагын төсөв | БТАрга зүйч Н.Ерөөлт-Очир Биеийн тамирын багш Б.Норовсамбу, Э.Сүнжидмаа |
| 39 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.2.2 дах заалт | Аймаг бүсийн аварга шалгаруулах өсвөрийн болон насанд хүрэгчдийн уралдаан тэмцээн зохион байгуулах | Зохион байгуулагдсан уралдаан тэмцээний тоогоор | Спортын мастер С.Нандинцэцэгийн нэрэмжит тэмцээн зохион байгуулагдсан | Тэмцээн уралдаан зохиогдсон байна | Орон нутгийн төсөв | БТАрга зүйч Н.Ерөөлт-Очир |
| 40 | | Брэнд спорт болох гар бөмбөг, ширээний теннис, шатар даам, гэх мэт спортуудыг дэмжих, цол зэрэгтэй тамирчдын тоог нэмэгдүүлэх | Зохион байгуулагдсан уралдаан тэмцээний тоогоор | Спортын мастер С.Нандинцэцэгийн нэрэмжит тэмцээн зохион байгуулагдсан | Сонгон дугуйлангийн тоог нэмэгдүүлэх, уралдаан тэмцээнд оролцуулж цол зэргийн болзол хангуулсан байх. | ОНТөсөв, бусад эх үүсвэр | Засаг дарга, ИТХ, БТСАрга зүйч |
| 41 | | Тив, дэлхий, олон улс, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан тамирчид, иргэдэд урамшуулал олгох | Журамд өөрчлөлт орсноор | Хуучин журам мөрдөгдөж байгаа | Урамшуулал, дэмжлэгийн хэмжээг өөрчилж мөрдөж ажиллана. | ЗДНөөц хөрөнгө | Албан байгууллагууд, арга зүйч |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | журамд нэмэлт өөрчлөлт оруулах | | | | | |
| 42 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.2.3 дах заалт | Оны аварга шалгаруулах спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулах, шилдэгүүдийг шалгаруулах | Зохион байгуулагдсан уралдаан тэмцээний тоогоор | Жил бүр уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн | Олон төрөлд тэмцээн зохион байгуулагдаж оны шилдэгүүд шалгарсан байна. | ОНТ, Төсөвт албан байгууллагууд | Ивээн тэтгэгч, зохион байгуулагч байгууллагууд |
| 43 | | Воллейболын элсний задгай талбай бий болох | Бүх насны иргэд хамрагдах боломжтой | Баянцагаан сумд нарийн ширхэгтэй элс бэлэн байгаа. | Талбайг бүрэн байгуулах. | Орон нутгийн төсөв | БТСАЗүйч |
| **2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **2.1 Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал** | | | | | | | |
| 44 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.2.1 дэх заалт | Сумын төвийн суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг гаргаж, хэрэгжүүлнэ. | Сумын төвийн хөгжлийн төлөвлөгөөтэй болсон байна. | Суурин газрын хөгжлийн төлөвлөгөөгүй байгаа | Төлөвлөгөө боловсруулагдсан байна. | ОНХС-300,0 | ЗДО, Газрын даамал |
| 45 | | Соёл амралтын хүрээлэнг шинэ төлөвлөлтөөр тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ. | Тохижилт үйлчилгээний ажлууд хийгдэж дууссан байна. | 2024 онд стандартын сагсан бөмбөгийн талбай | Шат дараалсан тохижолтын ажлууд хийгдсэн байна. | ОНХСан 109365,8 сая | ЗДТГ |
| 46 | | Эрчим хүчний өргөтгөл засвар үйлчилгээний ажлыг цаг тухайд нь хийлгэх | Эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болно | Тогны хүчин чадал муу байгаа. | Шаардлагтай засвар үйлчилгээг хийлгэсэн байна. | ОНХСан, бусад эх үүсвэр | ЗДТГ |
| 47 | | Хөдөөгийн багууд (Гичгэнэ, Дэлгэрэх, Цэцэн), Худаг уст цэгүүдийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн доголдлыг арилгах | Эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болно | Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадал муу байгаа. | Багуудын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр найдвартай ажилладаг болсон байна. | ОНХСан 16,0 сая | ИТХ, ЗДТГ |
| 48 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.2.4 дэх заалт | Үүрэн холбооны сүлжээний өргөтгөлийг хийх, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамрагдах байдлыг нэмэгдүүлэх | Хөндлөн хөх, сумын төв, Үнхэлцэгийн нуруу, Унтаагийн цахир | Зах зээлийн өрсөлдөөн байхгүй | Үүрэн холбооны сүлжээний өргөтгөлийг хийгдсэн байна. | Үүрэн холбооны операторууд | ИТХ, ЗДТГ |
| **3. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **3.1 Эрүүл мал –Эрүүл хүнс –Эко үйлдвэрлэл** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.4 дэхь заалт | "Хөдөө аж ахуйн нэг өдөр" өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулна | Өдөрлөгийн арга хэмжээ жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулагдсанаар | Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. | Өдөрлөгийн арга хэмжээний үр дүнд ЖДҮ, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна | ЗДНөөц 3 сая | ЗДТГ, ХААТ, МЭҮТ |
| 50 | | "Тэмээчдийн баяр"-ыг зохион байгуулна. | Тэмээчдийн баярыг зохион байгуулснаар | Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. | Тэмээний баяр зохион байгуулж тэмээний ашиг тусыг сурталчлах | ЗДНөөц 2,0 сая | ЗДТГ, ХААТ, МЭҮТ |
| 51 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.5 дахь заалт | Өвөлжөө хаваржааг хугацаа зааж чөлөөлөх засаг даргын захирамжыг шинэчилж, Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Бэлчээрийг зүй зохистой, улирлын хуваарьтай ашиглах оновчтой бодлого хэрэгжүүлэх | 2019 онд ИТХ-аар Бэлчээр ашиглалтыг хариуцлагжуулах журам баталсан хэрэгжилт хангалтгүй байгаа | Бэлчээр ашиглалтын журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлснээр маргаан шийдвэрлэх | Байгууллагын төсөв | ЗДТГ, ХААТ, багийн засаг дарга нар |
| 52 | | Бэлчээрийг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бэлчээрийн хортон мэргэчидтэй тэмцэх | Ариутгал хийсэн талбайн хэмжээгээр | Бэлчээрийн хортон мэргэчид нэмэгдэж байна. | Ариутгал хийгдсэн байна. | Улсын төсөв, Төсөл хөтөлбөрийн байгууллага 5 сая | ЗДТГ, ХААТ, МЭТ, БЗД нар |
| 53 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.5 дахь заалт | Цагаан алт хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлэх | Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн тоогоор | 2025 онд хэрэгжинэ | Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна. | Төсөл хөтөлбөр , хөрөнгө оруулагч | ХААТасаг |
| 54 | | "Шинэ хоршоо хөдөлгөөн", "Чинээлэг малчин" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, Хоршоодын үйл ажиллагааг бодлогоор дэмжих | Шинээр хоршоотой болох иргэдийг сургалтад хамруулж мэдээллээр хангах | Сумын хэмжээнд шинэ хоршоо хөдөлгөөнд 5 малчин өрх хамрагдсан | Хөтөлбөрт хамрагдаж хоршоонд хамрагдсан малчин өрхийн тоогоор | Төсөл хөтөлбөр , хөрөнгө оруулагч | ЗДТГ, ХААТ, МЭТ, БЗД нар |
| 55 | | Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх | Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх | өвс 10 тн, тэжээл 5 тн-оос багагүй бэлтгэсэн байна. | Гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөц бүрдүүлсэн байна. | ОНХС 20 сая | ХААТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.1 дэхь заалт | Гүн өрмийн болон энгийн уурхай худгуудыг засварлах ашиглалтын гэрээг шинэчлэн байгуулах, нарны өргүүртэй гүн өрмийн худаг гаргах | 1 худаг гаргах, 7 худаг сэргээн засварлах. | Бэлчээрийн усан хангамж дутмаг байна. | Худаг гарсан байна. | ОНХС 119,9 сая | ХААТасаг |
| 57 | | Сумын төвд өвс тэжээлийн агуулах барих | Өвс тэжээлийн агуулах баригдсан байна. | Сумын нөөцийн өвс тэжээлийн агуулахгүй байгаа | Агуулах баригдсан байна. | ОНХС-100,0 сая | ЗДТГ, ХААТ |
| 58 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.2.1 дэхь заалт | Цагдуултайн услалтын системийг түшиглэсэн газар тариалангийн талбайд шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтын ажлыг хийж хэрэгжүүлэх | Услалтын системийн ашиглалтыг сайжруулж тариалалт хийх | Услалтын системийн ашиглалт муу | Тариалалтын хэмжээ нэмэгдсэн байна. Тэжээлийн ургамал тариалалт 30 га-д хүргэх | ОНХС 40 сая | ХААТасаг, төсөл хөтөлбөрийн байгууллага |
| 59 | | Төмс хүнсний ногооны тариалалтыг 10 га хүргэх | 10 га талбайд хүргэх | 2024 оны байдлаар 5 га талбай | Тариалалт нэмэгдсэн байна. | ОНТөсөв | ЗДТГ, ХААТ |
| 60 | | Жимс жимсгэнэ, хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлж бодлогоор дэмжих | 3 га талбайд хүргэх | 2024 оны байдлаар 1 га талбай байна. | Хүлэмжийн тариалалт нэмэгдсэн байна. | ОНТ | ЗДТГ, ХААТ |
| 61 | | Бог малын хээлтүүлэгчийг 100%Бод малын хээлтүүлэгчийг 5% ангилалтад хамруулж бүртгэлжүүлнэ. | Ангилалт хийсэн хээлтүүлэгчийн тоогоор | Ангилалтад 4 суурийн 284 хуц, 614 ухна хамрагдсан | Жилийн эцэст тоологдсон хээлтүүлэгчийг 100 хувь хамруулна. | Улсын төсөв, | ХААТасаг |
| 62 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.3 дахь заалт | Малчдын орлогыг нэмэгдүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх. | мал аж ахуйн түүхий эдийг зах зээлд борлуулах гарцыг олж иргэдэд зуучилна. | Малчид бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах мэдлэг муу байдаг | Мал, малын түүхий эдийг зах зээлд нийлүүлэх тал дээр малчидтай хамтарч төрийн зүгээс боломжит зах зээлд зуучилж, нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулалттай хэрэгжүүлж ажиллана | Төсөл хөтөлбөр ийн байгууллага | ХААТасаг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | | Залуу малчин хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлснээр | Хөтөлбөр байхгүй байгаа | Хөтөлбөр боловсруулж батлуулсан байна. | ОНТ, тухай бүр | ЗДТГ, ХААТ |
| 64 | | Малчдыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах | ЭМДаатгалын тухай хуулийг малчдад сурталчлах | Хууль эрх зүйн мэдлэг хомс, даатгалд хамрагдалт муу | Бүх малчдыг 100 хувь хамруулах Хамрагдалтын тоо- | Тухай бүр | ЭМТ, ХААТ |
| 65 | | Амьжиргааны баталгаажуулах түвшингээс доогуур орлоготой болон залуу өрх, малчдыг малжуулах | Малжуулсан өрхийн тоогоор | Эдийн засгийн хүндрэл тулгарч байгаа өнөөгийн нөхцөлд малчдыг бодлогоор дэмжих хэрэгцээ байна. | 10 өрхийг малжуулсан байна. | Багийн сан, бусад эх үүсвэр | ХААТасаг |
| 66 | | Үхэр сүргийн чанар сайжруулах | Сумын нийт малын 1,1 хувь /2050/ эзэлж байна | Монгол Үхэрийн тоо толгой цөөн | Тоо толгой өсч малын санар сайжран өрхийн амжиргаа сайжирсан байна | ОНХСан 20 сая | ЗДТГ, ХААТасаг |
| 67 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.7 дахь заалт | Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх үйлчилгээнд бүрэн хамруулах | Эрүүл малтай бүс статусаа бататгана | мал сүргийг сахуу, шөвөг яр, сохор догол, коли иж балнад, цусан халдварт, шүлхий, дотрын халдварт хордлого, зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх | Давхардсан тоогоор 189,000 мал эрүүлжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байна. | Улсын төсөв | МЭТасаг, ААН |
| 68 | | МЭТасгийг дуудлага үйлчилгээний мотоциклоор хангах | Дуудлага үйлчилгээний чанар сайжирсан байна | Албан хэрэгцээний унаагүй | Мотоцикльтой болсон байна. | Байгууллагын төсөв 3,5 сая | ЗДТГ МЭТасаг |
| 69 | | Мал сүргийг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх үйлчилгээнд бүрэн хамруулах | Малын гадна дотно шимэгч өвчинөөс бүрэн ангижрах эрүүл мал сүрэгтэй болох мөн зах зээлд нийлүүлэгдэх малын арьс, шир стандартын шаардлага хангасан шимэгч | Сумын хэмжээнд 142 000 мал сүргийг малын шимэгч өвчин болох хөх ширх, шар ширх, хачиг, хамуу зэрэг өвчнөөс бүрэн ангижрах урьдчилан сэргийлэх. | Нийт 142000 мал сүргийг малын шимэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, туулга, боловсруулалтын арга хэмжээнд хамруулсан байна. | Улсын төсөв | МЭТасаг, ААН |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өвчний гэмтэлгүй болох. | | | | |
| **3.2 Эх байгаль-Ногоон байгууламж** | | | | | | | |
| 70 | Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.3.1 дэх заалт | "Тэр бум мод" хөтөлберийн хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх мод тарих | Тарьж ургуулсан модны тоогоор | 2023 онд сумын хэмжээнд нийт 2 мянга орчим мод тарьсан | Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай, албан байгууллага, аж ахуй нэгж айл өрхүүд мод тарьсан байна. | Улсын төсөв, орон нутгийн төсөв | ЗДТГ, Байгаль орчин |
| 71 | | Ан агнуурын бүс нутгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Тарьж ургуулсан модны тоогоор | Ногоон байгууламж нэмэгдүүлэх шаардлагатай | Ногоон байгууламж нэмэгдүүлж мод тарьсан байн ю0 а. | Орон нутгийн төсөв 10сая | Хамгаалалтын захиргаа, Байгаль орчин |
| **3.3 Байгаль орчин** | | | | | | | |
| 72 | | Ан амьтан бүхий бүс нутагт биотехникийн арга хэмжээ авах | Амьтадын амьдрах орчин сайжирсан байна. | 2023 онд 5 цэгт биотехникийн арга хэмжээ авагдсан. | Тусгай зориулалттай агнуурын бүс нутаг, Цэцэн, Гичгэнэ уулуудад биотехникийн арга хэмжээ авна. | Орон нутгийн төсөв, ан агнуурын орлого 5,0 сая | Хамгаалалтын захиргаа, Байгаль орчин |
| 73 | | Идэвхтэн байгаль хамгаалагчид, байгаль хамгаалагчийг урамшуулал | Байгаль хамгаалагчдыг урамшуулснаар | Тусгай хамгаалалтын захиргааны 4 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байна | Идэвхтэн байгаль хамгаалагчидын урамшуулалыг олгосон байна. | БНАТО 11,9 сая | ЗДТГ, Хамгаалалтын захиргаа, Байгаль орчин |
| 74 | | Байгаль орчинтой ээлтэй байх чиглэлээр нөлөөлийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах | Сургалтанд хамрагдсан иргэдийн тоогоор | Сурагч, иргэдэд, ан амьтан, ус, ногоон байгууламж сэдвүүдээр сургалт хийсэн. | Байгаль орчинд ээлтэй байх сургалт мэдээлэл хүргэсэн байна. | Төсөл хөтөлбөр ийн байгуулл ага-3.0 | ЗДТГ, албан байгууллагууд |
| 75 | | Хууль бус ан амьтаны талаар мэдээллийн самбар байршуулах | Тус сумд байдаг ховордсон ан амьтны талаар мэдээллийг мэдээллийн самбар дээр байршуулах | Мэдээллийн самбар байршуулах шаардлагатай | Самбарыг хийж байршуулсан байна. | ОНХС, БНАТО, төсөл хөтөлбөр ийн байгуулл ага -5,0 | БО, ОНТХГ хамгаалалтын захиргаа |
| 76 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны | Хог хаягдалын менежментийг хэрэгжүүлэх, хоггүй сум | Байгаль орчинд байгаа ахуйн хог | Хөдөөгийн багуудын нутаг дэвсгэрт өрхөөс үүдэлтэй ахуйн хог хаягдал байгаль | 20 мянган га газрын хогийг иргэдийн оролцоотой нэгдсэн | ОНХС, БНАТО-22,0 | ЗДТГ, Төсөвт байгууллагууд, Байгаль орчин |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр 6.3.2 дахь заалт | аян өрнүүлэх, сумын нийт нутаг дэвсгэрийн хогийг цэвэрлэх | хаягдлыг цэвэрлэснээр | орчинд бохирдол учрууж байгаа. | зохион байгуулалттай цэвэрлэх | | |
| 77 | Баянцагаан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 26 дахь заалт | Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, газрын генератор ажиллуулах | Газрын генератор ажиллуулж, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлснээр | 1 газрын генератор, 3 ширхэг түлш байгаа | 2 газрын генератор, 5-8 ширхэг түлш шаардлагатай | ОНХС 12,0 сая | ЗДТГ, Цаг уурын өртөө, Байгаль орчин |
| 78 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.3.5 дахь заалт | Байгаль хамгаалах нөхөрлөл, нутгийн иргэдэд түшиглэсэн дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | Аялал жуулчлалын маршруттай болсон байна. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ | аялал жуулчлалын маршрут зураг байхгүй | Дотоодын ачлал жуулчлалын маршрутыг боловсруулж батлуулсан байна. | БНАТО, төсөл хөтөлбөр өөс | ЗДТГ, БОМ, Төсөвт албан байгууллагууд |
| **4. ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА, НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ** | | | | | | | |
| **4.1 Сайн засаглал,** | | | | | | | |
| 79 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 7.1.8 дахь заалт | Татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх татварын орлогыг нэмэгдүүлэх | төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна | Татвар хураалтын орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. | 100% | Байгууллагын төсөв | Татварын улсын байцаагч |
| 80 | | Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын сайн дурын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлэх | 350 иргэнд хүргэх | Сайн дурын даатгалд нийт 277 иргэн хамрагдаж байна. | 100 хувьд хүргэнэ | Байгууллагын төсөв | ЗДТГ, НДБ |
| 81 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 7.1.4 дахь заалт | Төрийн албан хаагчдын ёс зүй манлайллыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч сургалт зохион байгуулах | Байгууллага бүр дотооддоо сургалт зохион байгуулж хэвших | ТАХ зөвлөгөөн жил бүр болдог | Зохион байгуулсан байна. | Байгууллагын төсөв-0,5 | Төсөвт албан байгууллагууд |
| 82 | | Ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх, ёсзүйн алдаа, дутагдал гаргасан ТАХ хүлээлгэх хариуцлага арга хэмжээг нэмэгдүүлэх | Төрийн албан хаагчдын ёс зүй харилцаа хандлагыг нэмэгдүүлсэн байна. | Төсөвт албан байгууллагуудын төрийн албан хаагчидтай байгууллага тус бүрт нь хурал хийсэн | Зөрчил дутагдал гаргаагүй байна. | Байгууллагын төсөв-0,5 | Төсөвт албан байгууллагууд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 83 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 7.1.5 дахь заалт | Төрийн албан хаагчдыг нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд байгууллага тус бүр жил тутам хамруулах | Төрийн албан хаагчдыг жил тутамд эрүүл мэндийн цогц үзлэг оношилгоонд хамруулсан байна. | Төсөвт албан байгууллагууд 2 жил тутамд 1 удаа хамруулж байна. | Бүх байгууллагууд үзлэг шинжилгээнд хамруулсан байна. | Байгууллагын төсөв | Төсөвт албан байгууллагууд |
| 84 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.1.6 дахь заалт | ЗДТГ нийтлэг үйлчилгээний албаны менежментийг сайжруулах | Нийтлэг үйлчилгээний албаны гэрээт 5 ажилтны нийгмийн асуудал шийдвэрлэгдэнэ. | Нийтлэг үйлчилгээний албаны ажилтан албан хаагчдын цалин, хангамжийн хүрэлцээ муу байгаа. | Нийтлэг үйлчилгээний албаны зохион байгуулалт шинэ хэлбэрт шилжсэн байна. | Байгууллагын төсөв | ИТХ,ЗДТГ |
| 85 | | Засаг даргын Тамгын газрын албаны машины парк шинэчлэл хийх | Шинэ машинтай болсон байна | 470 маркын авто машиныг ОНӨГ хүлээлгэж өгсөн | Автомашины парк шинэчлэгдсэн байна. | Аймаг, сумын төсөв-100 сая | ЗД,ЗДТГазар |
| 86 | | Сумын хуучин стадион, моторын барилгыг буулгаж газар чөлөөлөх | Газар чөлөөлөгдсөнөөр | Ашиглалтын хугацаа дууссан, актлах жагсаалтад орсон | Хуучин барилгуудыг буулгасанаар | Байгууллагын төсөв | ИТХ, ЗДТГ |
| 87 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 7.1.3 дахь заалт | Газар зүйн нэрийн тодруулалт хийх | Хилийн цэсийн маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн байна | Хилийн цэсийн маргааны асуудлаар Чандмань сумын удирдлагууд Говь-Алтай аймгийн ГХБХБГазартай хамтарсан тодруулга хийж үр дүнд хүрээгүй | Нэрийн зурагт өөрчлөлт орсон байна. | ОНХСан 20,0 сая | ИТХ,ЗД, Газрын даамал |
| 88 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 7.1.4 дахь заалт | E-Mongolia системийн ашиглалтыг сайжруулах, иргэдэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх, сургалт мэдээлэл хийх | Сургалтад хамрагдсан хүний тоогоор | Сумын хэмжээнд 243 төрлийн лавлагаа, мэдээллийг олгож байна. | Лавлагаа, мэдээлэл нэмэгдэж иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг ойртуулна. | Улсын төсөв, орон нутгийн төсөв | ЗДТГ, Д.Хандармаа |
| 89 | | Архивын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангаж бичиг баримтыг бүрэн хүлээн авч ирээдүйд иргэн хүн хохирохгүй байх боломжийг бүрдүүлж ажиллах | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах | Баримтын тоогоор Баримтыг хуулийн хугацаанд хүлээлгэж өгөхгүй байна. | Баримтыг цаг тухай бүрд нь бүрэн мөлжээлгэж өгөх, баримтжуулах, бүрдүүлж, баталгаажуулах | Улсын төсөв, орон нутгийн төсөв | ЗДТГ Б.Үүрцайх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 90 | | Албан байгууллага бүрийг төсөв санхүүгийн зөрчилгүй, өр авлага үүсгэхгүй байх нөхцөл байдлыг хангаж төсвийн сахилга батыг нэмэгдүүлнэ. | Төсөв санхүүгийн зөрчилгүй, өр авлага үүсгэхгүй | Санхүүгийн чиглэлээр сургалт мэдээллийг иргэд, төрийн албан хаагч нарт хүргэх, сургалтад хамруулах | төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна | Улсын төсөв, орон нутгийн төсөв | Төсөвт албан байгууллагууд, Санхүүгийн алба |
| 91 | "Сумын засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 7.1.8 дахь заалт | Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн албан хаагчдын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдын нэгдсэн өдөрлөг хийх | Төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа нэмэгдсэн байна. | Төрийн албан хаагчдын зөвлөлгөөн зохион байгуулсан | Төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа нэмэгдсэн байна. | ОНХСан 6,7 сая | Төсөвт албан байгууллага, ҮЭвлэл |
| 92 | | Ардын хувьсгалын баяр наадам зохион байгуулна | Баяр наадам зохион байгуулагдснаар | Баяр наадмын үйл ажиллагаа жил бүр зохион байгуулагддаг | Ардын хувсгалын баяр наадмын үйл ажиллагааг өргөн дэлгэр зохион байуулна | ОНХС 5 сая | ИТХ, ЗДТГ |
| **4.2 Нийгмийн аюулгүй байдал** | | | | | | | |
| 93 | Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.1.1 дэхь заалт | Иргэдийг чадавхжуулах, гамшиг, аюулаас сэргийлэх сургалт, авран хамгаалах зохион байгуулалтыг дэмжин, орон нутгийн хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах | Иргэдийг чадавхжуулах, гамшиг, аюулаас сэргийлэх сургалт зохион байгуулагдсан байна. | нийтийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа | Иргэдийн мэдлэг сайжирч, чадавхжсан байна. | Улсын төсөв, орон нутгийн төсөв | ЭХАБ, ИТХ, ЗД |
| 94 | | ЭХАБүлгийн ажиллах хүрээний сумд буюу бүсийн төвийн "Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн"-ийн гишүүдийн дунд туршлага солилцох сургалт, уулзалт, нөхөрсөг тэмцээн зохион байгуулах | Бүсийн арга хэмжээ зохион байгуулах, хууль сурталчлах ++ | Туршлага солилцох сургалт, уулзалт, нөхөрсөг тэмцээн зохион байгуулагдсан байна. | Амар буянт бүсийн төвийн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны цар хүрээ өргөжинө. | ЗД нөөц хөрөнгө 2,5 сая | ЭХАБ, ЗДТГ, Онцгой комисс |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 95 | | Цагдаагийн хэсгийн унааг шийдвэрлэнэ. | Автомашинтай болсноор | Хуучин машин үйлчилгээнд явахгүй байгаа, | Автомашинтай болсон байна. | Орон нутгийн төсөв, БНАТО- 20 сая | ИТХ, ЗДТГ |
| 96 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж өсвөр залуу үеийг цэрэг эх оронч үзлээр төлөвшүүлэхэд анхаарч ажиллана | Цэргийн жинхэнэ албанд татагдсан залуучуудын тоо, сургалтад хамрагдсан, хүүхэд хүмүүсийн тоо | Хариуцлагатай эх оронч үзлийн төлөвшүүлэхэд анхаарч ажиллана. | Цэргийн бүртгэл, цэрэг татлага, Монгол цэргийн өдрүүдээр холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна | Улсын төсөв, орон нутгийн төсөв | ЗДТГазар, Төсвийн байгууллагууд, БЗД нар |
| 97 | | Марш тактикийн тэмцээн зохион байгуулна. | тэмцээн зохион байгуулагдсан байна. | Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг | Хүүхэд залуучууд цэрэг, эх оронч үзэл төлөвшинө | орон нутгийн төсөв, ЗДНХ | ЗДТГ |
| 98 | Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13.1 | Хохирогчийг түр хамгаалах байртай болгох ажлыг эрчимжүүлэх | Хохирогчийг түр хамгаалах байргүй | Хамтарсан багийн хурлаар хэлэлцэх | Хохирогчийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, мөн сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх таатай орчин бүрдэнэ. | ОНТөсөв, бусад эх үүсвэр | Хамтарсан баг |

___________ooOoo_________